



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-24-80, Факс: 263727

И-мэйл: info@mecs.gov.mn Веб сайт: meds.gov.mn

2021. 01. 04 № 14/05
танай _____-ны № _____-т

АЙМГИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛ
УРЛАГИЙН ГАЗАР, НИЙСЛЭЛИЙН
БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН ДАРГА
НАРТ

Чиглэл хүргүүлэх тухай

Манай улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүд дэлхий нийтийн чиг хандлагад нийцүүлэн хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлэх, хэнийг ч үл ялгаварлан боловсролд хамруулах асуудлыг суурь зарчим, үндсэн зорилго болгон тусгаж, хэрэгжилтийг хангах хөтөлбөр, төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, салбар дундын уялдаа холбоог хангах арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.”, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд “2.3.Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.” гэж тус тус тусгасан.

Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг аль болох эрт илрүүлэх, боловсролын үйлчилгээнд эрт хамруулах, ердийн хүүхэдтэй хамтад нь хөгжүүлэх нь тэдний хөгжилд төдий чинээ ахиц дэвшил гардаг талаар туршлага, сургамж цөөнгүй байна.

Иймд тус яамнаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн цэцэрлэг, сургууль, насан туршийн боловсролын төвд тэгш хамран сургах, зайлшгүй тохиолдолд тусгай цэцэрлэг, сургуульд хамруулан боловсрол олгох бодлого баримтлан, холбогдох эрх зүйн орчин бүрдүүлэх, багш, мэргэжилтнийг давтан бэлтгэх, сургалтын орчин бүрдүүлэх ажлыг шат дараатай төлөвлөн хэрэгжүүлснээр тодорхой ахиц гарч байна. Гэсэн хэдий ч сургалтын тэгш хүртээмжтэй орчин бүрдүүлэх, багш, мэргэжилтнийг арга зүйгээр хангах, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн хандлагыг өөрчлөх зэрэг тулгамдаж буй бэрхшээлтэй асуудлууд байсаар байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэх, сайн туршлага бий болгох, түгээн дэлгэрүүлэх зэрэгт энэ чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд ихээхэн дэмжлэг болж байна.

Өнгөрсөн оны ажлаа дүгнэж, шинэ онд хийх ажлын төлөвлөгөө боловсруулж буй энэ цаг үед Боловсролын газар, хэлтэс болон асуудал хариуцан ажиллаж буй мэргэжилтэн бүр цаашдын үйл ажиллагаандаа тусгах талаар дараах чиглэлийг хүргүүлж байна. Үүнд:

14219 0042

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн гадна, дотно орчныг хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй болгох талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд, аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний заалтыг хэрэгжүүлэх чиглэлээр сургалтын байгууллагын удирдлагуудад зөвлөмж өгч, дэмжиж хамтран ажиллах;

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн статистик мэдээллийг бодитой болгох, боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулах чиглэлээр нутгийн захиргааны болон холбогдох бусад байгууллагатай байгууллагатай хамтран ажиллах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

3. Орон нутгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын шийдвэрийн дагуу боловсролд хамрагдаж байгаа байдалд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийг тохирох боловсролд хамруулах "Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл"-ийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

5. Цэцэрлэг, сургуульд хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамруулах ажлыг насан туршийн боловсролын төвтэй хамтран зохион байгуулж, үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

6. Ердийн цэцэрлэг, сургууль, насан туршийн боловсролд хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагаас дэмжлэг авах;

7. Тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр батлагдсан тогтоол, тушаал, журам, чиглэлийг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, мөрдөж ажиллах, хэрэгжүүлэх, хяналт тавих;

8. Олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулах онлайн сургалтад тэгш хамран сургалт хариуцсан мэргэжилтнүүд оролцох;


9. Тэгш хамран сургалт хариуцсан мэргэжилтэн нар судлагдахуун хариуцсан бусад мэргэжилтэн болон цэцэрлэг, сургуулийн удирдлага, сургууль дээрх "Дэмжлэгийн баг"-ийн үйл ажиллагааг арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

10. Ковид 19 цар тахлын хорио цээрийн дэглэм үргэлжлэх тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээний салшгүй хэсэг болгон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын тасралтгүй байдлыг хангах.

Тэгш хамран сургалтын чиглэлээр холбогдох зарим баримт бичгийн жагсаалтыг хавсралтаар хүргүүлэв.

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.ГАНЦЭЦЭГ



ШИНЭЭР БАТЛАГДСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

№	Эрх зүйн баримт бичгийн нэр	БАТЛАГДСАН ОГНОО	ДУГААР
1	“Хүүхдийн цэцэрлэгийн сэргээн засалч багшийн албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолт”	2019.07.05	A/430
2	“Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр”-ийг баталсан. Хоёр. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй”-н хэсэгт Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн хөгжлийг хэрхэн дэмжих вэ?, Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хэрхэн боловсруулах вэ?	2019.08.02	A/494
3	“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам”	2019.05.14	A/292
4	“Гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай” Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээний үлгэрчилсэн загвар	2019.08.15	A/508
5	“Чиглэл батлах тухай”	2019.08.27	A/528
9	“Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журам”-ыг баталсан	2019.12.17	A/803
10	“Насан туршийн боловсрол” хөтөлбөр	2019.11.28	A/756
11	“ Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хөгжлийг дэмжих танхимын үйл ажиллагаанд баримтлах чиглэл”	2020.	A/249
12	“ Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багш, туслах багшид нэмэгдэл хөлс олгох заавар”	2020	A/296
13	Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох	2020	A/184

	хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам”		
14	“Журамд нэмэлт өөрчлөлт орох тухай” Засгийн газрын тогтоол	2020	208
15	“Тэгш хамран сургах боловсролын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоол	2020	235
Батлагдсан сургалтын хөтөлбөр, стандарт			
1	“Яриа бичиг” жишиг сургалтын хөтөлбөр	2020	A/305
2	“Тусгай сургуулиудын сургалтын төлөвлөгөө”	2020	A/37
3	“Монгол брайль бичгийн стандарт” MNS6800:2019	2019.	2019 оны СХЗГ-ын даргын С/58 тоот тушаалаар
4	“Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдлын Ерөнхий шаардлага” MNS6782:2019	2019	2019 оны СХЗГ-ын даргын С/40 тоот
5	“Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль түүний дотуур байрны орчны эрүүл ахуйн шаардлага” MNS6799:2019	2019	2019 оны СХЗГ-ын даргын С/40 тоот